

# ГАН ХИЙЦ ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2020 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

2020 онд Ган хийц ХК-ийн үндсэн үйлдвэрлэл дараах чиглэлүүдээр явагдсан. Үүнд:

- Төмөр хийц эдлэл үйлдвэрлэл
- Барилга угсралт

Ган хийц ХК-ийн 2020 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал, ЗАА зардлын төсөв, борлуулалтын хэмжээг дараах байдлаар баталж өгсөн байна.

№	Нэр	Төсөв
1	ТУЗ-ийн зардал	134235600
2	ЗАА зардал	600238660
3	Төмөр хийц үйлдвэрлэл, барилга угсралтын борлуулалт	2403500187.11

Ган хийц ХК 2020 он хийгдэж байгаа ажлууд

Д/д	Захиалагч компани	Нийт гэрээний дүн	Санхүүжилт хийгдсэн дүн
1	Онцгой байдлын ерөнхий газар	450,000,000.00	315,000,000.00
2	Бэр сүм ХХК	75,000,000.00	30,000,000.00
3	Цэцэн урчууд ХХК	11,754,172.00	11,754,172.00
4	Есүй ордон ХХК	3,328,063.00	3,328,063.00
5	Төрийн тусгай хамгаалалт	4,657,125.00	4,657,125.00
6	Мобиком ХХК	3,650,346.67	3,650,346.67
9	Нийт дүн	<b>548,389,706.67</b>	<b>368,389,706.67</b>

## Онцгой байдлын ерөнхий газрын спорт заалны барилга угсралт



### ***УДИРДЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ***

#### **ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл**

Ган хийц ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр компанийн тухай хууль болон компанийн дүрмээр олгосон бүрэн эрхийн хүрээнд тогтвортой, тасралтгүй үйл ажиллагаа явуулж ирлээ.

2020 оны 04 дүгээр сарын 14 -ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Д.Оюунзулыг чөлөөлж, Б.Гантулгыг томилон ажиллуулсан.

Ган хийц ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат гишүүнээр М.Даваасүрэн, Б.Эрдэнэбаяр, Ц.Пүрэвжаргал, Б.Ганбат, Э.Долгорсүрэн, Ц.Хангай, Б.Гантулга нарыг, Хараат бус гишүүнээр Д.Сайнбаяр, Д.Энхбаатар, Ц.Жанлав нарыг бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

ТУЗ-ийн 2020 оны 03 сарын 20-ны өдрийн хурлаар Ган хийц ХК-ийн Гүйцэтгэх захирлаар Даваасүрэн овогтой Оюунзулыг томилсон.

## Орон тоо бүтцийн талаар:

2020 оны ТУЗ болон Захиргаа, үйлчилгээний хэсгийн орон тоо цалингийн төсвийг дараах байдлаар баталсан.

№		Төсөв
1	Захиргаа, үйлчилгээний хэсгийн орон тоо, цалингийн сан	317316000
2	Төлөөлөн удирдах зөвлөлийн цалингийн зардал	64560000

Компанийн мэдээллийн ил тод байдлыг хангах үүднээс [www.gankhiits.mn](http://www.gankhiits.mn) веб сайт шинэчлэгдэж, Хувьцаа эзэмшигчдэд зориулан булан гаргасан бөгөөд компанийн холбогдолтой бүхий л мэдээллийг авах боломжтой юм.

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2020 оны хагас жилийн санхүүгийн тайланг хавсралт-1-ээр үзүүлэв.

Төмөр хийцийн үйлдвэрлэлтийн хэмжээ /тонн жин/				
Д/д	Бүтээгдэхүүн	хэмжих нэгж	2019 оны 2 улирал	2020 оны 2 улирал
1	Үйлдвэрлэсэн төмөр хийц	тонн	<b>95.6</b>	<b>66.98</b>

## Зардлын задаргаа харьцуулалт

Д/д	Зардлын нэр	2019 оны 2 улирал	2020 оны 2 улирал
1	Захиргаа аж ахуйн зардал	213,209,829.61	180,907,901.56
2	ТУЗ-ийн зардал	37,554,208.20	46,261,712.85
3	Бусад зардал	12,546,494.95	16,960,886.46
	<b>Нийт зардал</b>	<b>263,310,532.76</b>	<b>244,130,500.87</b>

## НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Компанийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, 48.3, 48.4 заалтуудыг үндэслэн, 2019 оны Санхүүгийн тайланг хархад Ган хийц ХК нь -240 801 776,93 төгрөгийн алдагдалтай гарсан тул энэ жил ногдол ашиг тараахгүй гэсэн ТУЗ-ийн шийдвэр гарсан тул Хувьцаа эзэмшигчдэдээ танилцуулсан.

